



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/111

Чойр

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам” А/187 дугаар тушаал, Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 93 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хишиг ойл ХХК нь (6186815) Сүмбэр сумын Ганзам багийн Ганзам 9-901 тоотод байрлах аж ахуйн хашааны зориулалттай 56166м² газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах хүсэлт гаргасан тул 15 жилийн хугацаатайгаар сунган эзэмшүүлсүгэй.

2. Хуулийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулан авч буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой эзэмшиж, газар эзэмших гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг (Хишиг ойл ХХК)-д үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулан авч буй Хишиг ойл ХХК-д эзэмшил газрын кадастрын ажил гүйцэтгүүлэх хуудас болон газар эзэмших гэрээ, гэрчилгээг цахимаар үүсгэж, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Отгончимэг)-д зөвшөөрсүгэй.


4. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/194 дугаар захирамжийн хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

4212400262



Аймгийн Засаг даргын 2024 оны
03 сарын 19-ны өдрийн 1/277 дугаар
захирамжийн хавсралт



Хишиг ойл ХХК-ийн эзэмшил газрын хугацааг сунгаж буй газрын байршлын зураг

Сумын нэр	Багийн дугаар	Газрын хэмжээ /м ² /	Эзэмших хугацаа /жил/	Газрын зориулалт	Газрын байршил, нэр
Сүмбэр	1	56166	15	Аж ахуйн хашааны	Ганзам 9-901 тоот

